

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
/2025 оны жилийн эцсийн байдлаар/

2025.12.15

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл, заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжээгүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
Засгийн газрын тогтоол							
1	Засгийн газрын тогтоол 2025.02.19 №103	1	“Тавантолгой- Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”	Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/75, А/18 тоот тушаал батлагдаж, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шаардлагатай чиг үүрэг болон 507 орон тоог шилжүүлсэн.	100%		
2	Төмөр замын барилгын ажлын зөвшөөрөл олгох тухай 2025.03.26 №156	2	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2025 оны 05 дугаар сард багтаан эхлүүлэхийг “Тавантолгой төмөр зам” ХХК (Б.Дүгэржав), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Х.Мөнхжаргал)-д даалгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг 2025 оны 05 дугаар сард багтаан эхлүүлэхийг “Тавантолгой төмөр зам” ХХК үүрэг болгосугай гэсний дагуу 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр БНХАУ-ын “Төмөр замын	100%		

			Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд үүрэг болгосугай. /Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 (таван) жилийн хугацаатай олгосугай/	барилгын гүүрийн инженерийн товчоо групп” ХХК-тай барилга угсралтын гэрээ эцэслэсэн.Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 5.34%-тай үргэлжилж байна. 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Авто зам, замын байгууламжийг барих, засварлахад техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх 2025/03/068 дугаартай тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай авсан.			
3	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах тухай 2025.03.26 №157	3	1.Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Гаалийн	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 157 дугаар тогтоолоор Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг даалгасан. Энэ хүрээнд Монгол Улсын Сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2025 оны 04 сарын 10-ны өдрийн А/30 тушаалаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын бүсэд техник, тоног төхөөрөмж, барилгын болон өдөр тутмын бараа		БНХАУ-ын албан ёсны шийдвэр хүлээж байна. 30%	

			ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хил хамгаалах ерөнхий газар (Х.Лхагвасүрэн), Гадаадын иргэн, харьяатын газар (Н.Ууганбаяр), Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбат, "Тавантолгой төмөр зам" ХХК (Б.Дүгэржав)-д даалгасугай.	материалыг улсын хилээр нэвтрүүлэх зохицуулалтыг хийх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай ажлын уялдаа холбоог хангаж, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан ба ажлын хэсэг нийт 5 удаагийн хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Монгол Улсын Боомтын захиргаа болон ӨМӨЗО Боомтын захиргаатай "Бүтээн байгуулалтын хаалттай бүс"-д мөрдөх түр журмыг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 30-ны өдрийн хооронд батлахаар тохирсон боловч өнөөг хүртэл батлагдаагүй байна. "Бүтээн байгуулалтын хаалттай бүс"-д мөрдөх түр журмын төслийг боловсруулан, Хятадын талд 2 удаа хүргүүлэн ажилласан бөгөөд одоогийн байдлаар Хятадын талын Гаалийн ерөнхий газраас түр журмыг судлан, чиглэл өгөх талаар ӨМӨЗО-ны Боомтын захиргаанаас мэдэгдсэн байна. Гүйцэтгэгч талаас 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр хоёр компанийн хооронд зохион байгуулагдсан уулзалтанд "Бүтээн байгуулалтын хаалттай бүс"-д мөрдөх түр журам батлагдаагүйн улмаас барилгын ажил удаашралтай явагдаж байгаа талаар			
--	--	--	--	--	--	--	--

				мэдэгдсэн. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд хилийн "О" цэгт, түр гарцаар техник, тоног төхөөрөмж, барилгын болон өдөр тутмын бараа материалыг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх хүсэлтийг "Хятадын төмөр замын барилгын корпорацын гүүрэн барилгын товчоо групп Монголиа" ХХК-иас 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн ZMKJTL-2025-19 дугаартай албан бичгээр "Тавантолгой төмөр зам" ХХК-д ирүүлсэн. Энэ зохицуулалтыг хийх ажлын хүрээнд "Тавантолгой төмөр зам" ХХК-иас Ажлын хэсгийг яаралтай хуралдуулах хүсэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 01/1638 дугаартай албан бичгээр Хилийн боомтын захиргааны дарга бөгөөд Ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 18-ны өдрүүдэд Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захиргааны алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн 2025 оны 2, 3 дугаар улирлын хурлаар "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар,			
--	--	--	--	---	--	--	--

[illegible]

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл							
5	ЗТЯ, “ЭТТ”ХК, “ТТЗ” ХХК, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2025.05.28 №25 хурлын тэмдэглэл	5	Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн төсөвт өртгийн өөрчлөлтийн талаар Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Гашуунсухайт- Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн төсөвт өөрчлөлт оруулах талаар Хятадын талаас ирүүлсэн саналыг судалж, хэлэлцээ хийх замаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлж шийдвэрлэхийг Зам, тээврийн сайд Б.дэлгэрсайхан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасурэн), ”Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Артур), ”Тавантолгой төмөр зам” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага (Б.Дүгэржав) нарт даалгав.” гэжээ.	Монгол Улсын Засгийн газраас өгсөн чиглэлийн хүрээнд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 03/2549 дугаартай албан бичгээр Зам, тээврийн Сайдын 2024 оны А/243 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг”, “Авто зам, замын байгууламжийн машин механизмын ашиглалтын нэг машин цагийн үнэ”-ийг тус тус баримтлан төсөвт өртгийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар магадлуулах чиглэлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д ирүүлсэн. Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн яамны өгсөн чиглэлийн дагуу “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ- ын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 126/2025 дугаар “Магадлалын ерөнхий дүгнэлт”-ээр магадлуулсан бөгөөд Зам, тээврийн Сайдын 2025 оны 08 дугаар сарын 13- ны өдрийн 01/3691 дүгээр албан бичгээр дэлхийн зах	100%		

				зээл дээр нүүрсний үнэ унасан, улсын эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдлыг харгалзан тэвчиж, хойшлуулж болох зардлуудыг хасах замаар төслийн өртгийг бууруулах арга хэмжээ авахыг чиглэл болгосны дагуу дахин 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 208/2025 дугаар “Магадлалын ерөнхий дүгнэлт”-ээр магадлуулсан.			
6	Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга	6	1.2.төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүй байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад;	Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 08 дугаартай тогтоолоор ажиллах хүчний орон тоог 120 байхаар баталсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1192 тоот албан бичгээр төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь эдийн засгийн хүндрэлтэй болсон энэ цаг үед хэмнэлт хийн ажиллах чиглэл өгсөн. Компанийн хэрэгжүүлж буй Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийг хугацаанд нь бүрэн дуусгахад шаардлагатай захиалагчийн хяналтын инженер техникийн ажилтнуудын орон тоонд	100%		

	хэмжээний тухай 2025.07.25-ны өдрийн №04			нөлөөлөхгүй байх зарчмыг баримталж байгаа ч зайлшгүй дутуу орон тоон дээр хүн авах нөхцөл, шаардлага үүсч байна. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 16 дугаар тогтоолоор компанийн бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар орон тооны зохион байгуулалт, албан тушаалын зэрэглэл, цалингийн сүлжлийг шинэчлэн тогтоож орон тоог 10 хувиар бууруулж, 108 хүний орон тоотойгоор ажиллаж байна.			
		7	14.2.Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг хэвийн, тасралтгүй үргэлжлүүлэхэд онцгойлон анхаарч, цаашид Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Ханги-Мандал боомтуудыг төмөр замаар холбох асуудлаар хятадын талтай хийх	“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г 2025 оны 6 дугаар сарын 09-ний өдөр 24 сарын хугацаатайгаар байгуулсан бөгөөд БНХАУ-ын "Төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо" ХХК нь барилга угсралтын ажлыг		Хугацаа болоогүй.	

			яриа, хэлэлцээг “Эрдэс баялаг, эрчим хүч дэд бүтцийн хамтын ажиллагааны Монгол, Хятадын хамтарсан зөвлөл”-өөр дамжуулан эрчимжүүлэх.	5.34%-тайгаар гүйцэтгэж байна.			
Хэсгийн дундаж: 100 хувь							
Нийт дундаж: 91.2 хувь							